



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/623

Есөнбулаг

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, УИХ-ын "Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай" 2022 оны 36 дугаар тогтоол, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.4 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.5 дахь зорилтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хүнсний аюулгүй байдлын хүрээнд баталгаатай эрүүл хүнсээр иргэдийг хангаж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Хүргэлт-IV" нэгдсэн арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)


Гишүүд: Б.Бүрэнбаясах (Мал эмнэлгийн газрын дарга)
Т.Эрхэмбаяр (Аймгийн "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирал)

Н.Мэндбаяр (Цагдаагийн газрын дарга)
Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: С.Эрдэнэ-Очир (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга)

2. Тус арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн, дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Сүхбаатар)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

